



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/803

Булган сум

**Аймгийн аюулгүйн нөөцөд тэжээл
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 56 дугаар "Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 138/2025 дугаар "Аймгийн аюулгүйн нөөцөд тэжээл нийлүүлэх гэрээ"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Аймгийн аюулгүйн нөөцөд тэжээл нийлүүлэх" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Их баян болдог" ХХК-аас 60 тн тэжээлийг гэрээнд туссан байршилд хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
М.Лхагваням ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн ахлах менежер)
Л.Наранчимэг ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн менежер)
Л.Лхамаа (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: П.Хишигдаваа (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Аймгийн аюулгүйн нөөцөд техникийн тодорхойлолтын шаардлага хангасан тэжээлийг хүлээн авч, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т, хүлээн авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэж, баримт материал бүрдүүлж ажиллахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугар 2025 өдөр бүр Д...

6325011223